



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 02

Дугаар 22

Есөнбулаг сум

Салбар комиссын бүрэлдэхүүн  
батлах тухай.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. "Засагт ханы хурд-2017" хурдан морины уралдаанд уралдах морьдын үүлдэрлэг байдлыг тогтоох ажлыг зохион байгуулах салбар комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Салбар комиссын бүрэлдэхүүний унаа, шатахуун болон бусад зардлыг шийдвэрлэж, хурдан морьдын уралдааны явцад хяналт тавих нөхцөл бололцоог ханган хамгаалалтын арга хэмжээ авч ажиллахыг Цагдаагийн газрын дарга х/а /Г.Түмэннасан/, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга /Б.Мөнхжаргал/, Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга /Б.Баян-Эрдэнэ/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
 2017 оны 03 дугаар сарын 02 ны өдрийн  
 20 дугаар тогтоолын 1-р хавсралт

“ЗАСАГТ ХАНЫ ХУРД-2017” ХУРДАН МОРИНЫ УРАЛДААНД ОРОЛЦОХ МОРЬДЫН  
 ҮҮЛДЭРЛЭГ БАЙДЛЫГ ТОГТООХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: Н.Сандаг-Мал эмнэлгийн тасгийн дарга  
 Дэд дарга: Ж.Наранбаатар-Цагдаагийн газрын дэд дарга  
 Дэд дарга: С.Эрдэнэ-Очир-Мал эмнэлгийн Үржлийн албаны дарга  
 Дэд дарга: Г.Ганбат-ШШГА-ны Төлөөлөгч ахмад

Гишүүд: А.Хуншагай- ХХААГ-ын мэргэжилтэн  
 Ш.Мянганбаяр- Дарив сумын ЗДТГ-ын мэргэжилтэн  
 Х.Гантулга - Дэлгэр сумын ЗДТГ-ын мэргэжилтэн  
 Ц.Дашням- Дэлгэр сум  
 Н.Чилхаасүрэн - Тайшир сумын уяач  
 П.Авирмэд - Жаргалан сумын уяач  
 Х.Төртулга - Шарга сумын уяач  
 Д. Баттөр - Бигэр сумын уяач


Хамгаалалтанд ажиллах: 1. Цагдаагийн газрын албан хаагчид:

а/х Д.Сүрэн  
 а/х Т.Пүрэвбаяр  
 а/х Алтаншагай  
 д/ч Б.Очирхуяг  
 а/д Т.Даваажав  
 д/ч Т.Гэндэнсүрэн  
 д/ч О.Баярмагнай  
 д/ч Батцагаан  
 д/ч Г.Дашдэлэг  
 д/а ЖБүрнээбаяр  
 а/д С.Амартүвшин  
 д/ч П.Ууганбаатар  
 х/ч Д.Төгсбаяр  
 д/а Ш.Дамба

2. ШШГАлбаны албан хаагчид

а/д М.Бат-Ирээдүй ШШГА  
 а/д Г.Мөнхзул ШШГА  
 а/ч Г.Уртнасан ШШГА  
 а/ч П.Дашцэдэн ШШГА  
 а/ч Д.Ууганжолоо ШШГА  
 д/а Н.Ган-Эрдэнэ ШШГА  
 д/а Н.Баярмагнай ШШГА  
 а/ч Б.Мандахнаран ШШГА  
 д/а Г.Банзрагч ШШГА  
 Б.Баасанцэрэн ШШГА

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2017 оны 03 дугаар сарын 02 ны өдрийн  
02 дугаар тогтоолын... р хавсралт



**“ЗАСАГТ ХАНЫ ХУРД -2017” ХУРДАН МОРЬДЫН  
УРАЛДААНД ЭРЛИЙЗ АДУУ ЯЛГАХ УДИРДАМЖ**

2017.03.02.

Алтай хот

“Засагт ханы хурд-2017” хурдан морьдын уралдаанаас үүлдэрлэг байдлыг тогтоож, хасахад энэхүү журмыг мөрдөнө.

1. Морьдыг тусгайлан бэлтгэсэн хашаанд шүдэлж, үүлдэрлэг байдлыг тогтоож, эрлийз морьдын жагсаалт гарган морины комисс, зохион байгуулах хороонд мэдээлнэ.
2. Мандалтын дөрөлжөөс мордуулж Баян үзүүр хүртэлх замд ажиглалт хийнэ.
3. Эрлийз нь тогтоогдсон морьдын дугаарыг Цагдаагийн байгууллагын ажилтанд хэлж унаач хүүхдүүдийг нь тусгайлан бэлтгэсэн автомашинд суулгаж наадмын талбайд уяачдад хүлээлгэн өгнө.
4. Эрлийз морьдыг тусгайлан бэлтгэсэн хашаанд уяж тухайн насны хурдан морьд барианд орсны дараа уяачдад хүлээлгэн өгнө.
5. Хашаанаас гарааны төхөөрөмж, төхөөрөмжнөөс бариа хүртэлх замд уралдааны морьдод дахин ажиглалт хийж эрлийз морьдыг жагсаалтанд нэмж морины комисс, зохион байгуулах хороонд мэдээлнэ.
6. Айрагдсан морьдыг дахин үзэж үүлдэрлэг байдлыг тогтоож, саналаа морины комисс, зохион байгуулах хороонд хүргүүлж шийдвэр гаргуулна.
7. Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас ажиллаж буй бие бүрэлдэхүүн, үүлдэрлэг байдлыг тогтоох ажлын хэсгийн үйл ажиллагаанд уяач болон ард иргэд, албан тушаалтан ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүй байх орчинг бүрдүүлж, аюулгүй байдлыг хангаж ажиллах.
8. Хурдан морьдын үүлдэрлэг байдлыг шалгаж уралдааны замд гаргахад морь тавиач хүн явуулахгүй байх.
9. Хурдан морьдын үүлдэрлэг байдлыг тогтоох комиссын бүрэлдэхүүн гарааны газраас бариа хүртэл үүлдэрлэг байдлыг тогтоох, хяналт тавих нөхцөл бололцоогоор хангах.